

Эрт дээр үед Израильд Иона гэдэг хүн амьдардаг байжээ. Иона Бурханы үгийг дамжуулдаг хүн байлаа.

Нэгэн өдөр Бурхан Ионад ингэж хэлэв.

“Иона аа, чи Ниневе хот уруу очоод тэнд амьдардаг хүмүүст хандан муу зүйл хийхээ боль гэж дамжуул” гэжээ.

Ниневе нь маш том хот байлаа. Тэр хот нь баян бас хүчирхэг байлаа. Гэхдээ тэр хотын бүх ард иргэд нь бие биенээ хайрлахгүй эсрэгээрээ үргэлж өөрсдийн амин хувиа хичээн, өөрсдийнхөө төлөө л амьдарч байлаа.

Тиймээс ч Иона тэр хот руу явах тун дургүй байжээ. Иона Бурханы хэлсэн газар руу явалгүй, Таршиш руу явах усан онгоцонд суучихав.

Гэтэл төд удалгүй! Гэнэт хүчтэй салхи салхилж далайн хар шуурга Ионагийн суусан онгоцыг бүрхэн авав.

Онгоцон дээр байсан хүмүүс, хэнээс болж гэнэт шуурга дэгдэх болсоныг мэдэхээр шавга хаяжээ.

Гэтэл шавга Иона дээр очоод тогтов. Хүмүүс шуургыг зогсоохын тулд Ионаг далай руу шидчихэв.

Гайхалтай нь Ионаг далай руу шидэх агшинд шуурга ч нам зогсжээ.

Гэтэл далайд хаягдсан Ионаг нэгэн халим гэнэт гарч ирээд залгичихаж гэнэ.

Харин энэхүү халимыг Бурхан явуулсан байжээ. Харин Иона гурван өдөр гурван шөнө халимын гэдсэнд залбирангаа цагийг өнгөрүүлж байлаа. Тэгээд Бурхан Ионагийн залбиралыг сонсжээ. Гурван өдрийн дараа халим Ионаг хуурай газар дээр нулимаад гаргаж гэнэ. Ингэж Иона халимны гэдэснээс гарч амь аврагдаж гэнэ.

Ингээд Иона анх удаа Ниневед очиж Бурханы тушаасан тушаалын дагуу Бурханы үгийг дамжуулж байлаа.

Иона өдөржин хотоор явж чанга дуугаар Бурханы үгийг дамжуулж байлаа.


Ниневе хотын ард иргэд Ионагийн дамжуулж буй үгийг сонсоод ихэд айцгаав.

Тэгээд тэд хоол ундаа ч идэж үүлгүй Бурханд хандан чин сэтгэлээсээ залбирцгаав.

Харин Бурхан тэдний чин сэтгэлийн залбиралыг сонсож, тэр хотыг үүчилж өгчээ.

Иймийн тулд Ниневе хотын ард иргэд болон Ниневе хотын хана хэрэм хүртэл ямар ч сүйрэлтэй тулгараагүй ажээ.





- Дараах библийн эшлэлийг дагаж бицээд, цээжлээрэй. (Иона 4:11)



... тэдэнд санаа зовохгүй гэж үү?



Үйл ажиллагаа 2.

Ионагийн хэсгийг хайчилж аваад аврага загасны гэдсэн дээр наагаарай.

Хэрэглэгдэх материал: Хайч, цавуу.



Жишээ зураг









Нэр :